

**Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг  
хэрэгжүүлэх ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл**

Ажлын хэсгийн хуралдаан Төрийн ордны 4 давхарын зааланд 2007 оны 01 дүгээр сарын 04-ны өдөр 15.00 цагт болов. Ажлын хэсгийн хуралдаанд ажлын хэсгийн гишүүн Ерөнхий сайдын ахлах зөвлөх Д.Батбаяр, Үндэсний татварын ерөнхий газрын дарга Л.Зориг, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, УХЯ-ны геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын дарга Ц.Даваадорж, БОЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга Ц.Банзрагч, Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын Уул уурхайн албаны дарга Ж.Билэгсайхан, Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын ерөнхийлөгч Л.Дондог, Оюутолгой төслийн Үйлдвэр, худалдаа, засгийн газартай харилцах асуудал хариуцсан дэд захирал Содхүү, Монголын алт корпорацийн дэд ерөнхийлөгч Д.Дашзэвэг, Уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал Алгаа, "Монгол газар" компани Тамгийн газрын дарга Ж.Нарантунгалаг, "Нээлттэй нийгэм форум"-ын менежер Н.Дорждарь, "Ил тод байдал сан"-гийн тэргүүн Ц.Ганболд, "Информ" төвийн гүйцэтгэх захирал Р.Батпүрэв, "Миний монголын газар шороо" хөдөлгөөний гүйцэтгэх захирал Б.Болдбаатар, Байгаль орчны төрийн бус байгууллагын эвслийн зохицуулагч Ариунболор нар оролцов.

Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын зөвлөх С.Хасар, Үйлдвэр, худалдааны яамны Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын мэргэжилтэн М.Тодбилэг нар хуралдаанд урилгаар оролцов. Гишүүн Даваацэдэв гадаадад ажлаар явсан, Батжаргал саналаа бичгээр ирүүлсэн учир хуралдаанд оролцоогүй. Гишүүн Г.Зинамядар, Г.Гэрэлт-Од, Ц.Мөнхбаяр, Н.Дашзэвэг, Сандаг нар хуралд ирээгүй болно. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, материалыг гишүүдэд урьдчилан хүргүүлсэн байв.

Хуралдааныг нээж ажлын хэсгийн ахлагч Д.Батбаяр үг хэлэв. Хэлсэн үгийг хавсаргав.

Тэрээр ажлын хэсгийн хуралдаанаар нийт 7 асуудал хэлэлцэхээр материалаа урьдчилан хүргэсэн. Та бүхнийг танилцсан гэж найдаж байна. Саналаа төсөл дээрээ шууд засварлан өгч болно.

**ХЭЛЭЛЦСЭН нь:** Д.Батбаяр ажлын хэсгийн ажиллах дүрмийн төслийн талаар ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа танилцуулна гэв.

Э.Сумъяа: Ажлын хэсгийн ажиллах журмын төслийг өмнө болсон ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцээд төрийн бус байгууллагуудын эвсэл байгуулагдсаны дараа саналыг тусган дахин хэлэлцэхээр тогтсон. Журмын төсөлд зарим гишүүдээс санал авч тусгасан, ажлын хэсгийн үйл ажиллагаа оролцогч 3 талын зөвшилцлөөр явагдана гэж журмын төсөлд тодорхой

тусгасан. Зарим үг үсгийн засварууд хийгдсэн байгаа. Гишүүн Б.Батжаргалын журмын төсөлд бичгээр ирүүлсэн саналыг уншив.

Д.Батбаяр: Санаачлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа сайн дурын үндсэн дээр харилцан тэгш байрнаас, эхнээс нь хамтран хийж бүтээх гэсэн байр суурийг баримтлан ажиллаж байна. Та бүхнээс хамтарч ажиллахыг хүсч байна. Мөн асуудлыг улс төржүүлэлгүй, эрүүл бодитойгоор шийдвэрлүүлэх, хамтын хүчээр ажил хэрэг болгомоор байна. Хурлын явцад саналаа шууд чөлөөтэй ярилцаж асуудлаа батлаад явна.

Р.Батпүрэв: Ажлын хэсгийн ажиллах журамд ажлын хэсэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын албан бичгийн хуудас хэрэглэнэ, ажлын алба нь өөрийн гэсэн билэг тэмдэгтэй, албан бланк, тэмдэгтэй байна, энэ нь алба Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд байна гэжээ. Энэ нь бие даасан гэдэгтэй зөрчилдөж байна.

Э.Сумьяа: Ажлын хэсэг нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын албан бланк, тэмдэг хэрэглэнэ. Учир нь ажлын хэсэг орон тооны байгууллага биш, ажлын хэсгийг ахалж байгаа Ерөнхий сайдын ахлах зөвлөх Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бланк хэрэглэдэг. Харин ажлын алба бол бие даасан хуулийн этгээд хөндлөнгийн байгууллага учир албан бланк, тэмдэг хэрэглэнэ. Дэлхийн банкны зөвлөхүүд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Батболдтой уулзаж ажлын албыг Хэрэг эрхлэх газрын дэргэд байлгахаар тогтсон юм. Цаашдаа ажлын алба төсөвтэй байх хэрэгцээ гарна, төсөв нь аль нэг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт тусна, энэ утгаараа аль нэг сайдын харьяанд байхаас өөр үггүй. Хэрэв сайдаас хамааралтай биш байлгая гэвэл одоо байгуулагдаж байгаа Авилгалын эсрэг газрын харьяанд байлгаж болох юм.

Л.Дондог: 8.3-т редакцийн алдаа байна. 6.2 гэснийг 8.2 гэж өөрчлөх.

Э.Сумьяа: Хүлээж авлаа.

Ц.Ганболд: Ажиллах журам, ажлын албаны ажиллах дүрэмтэйгээ уялдаа муутай байна. Ажлын алба Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад тайлагнах гэдэг нь Засгийн газарт хамааралтай байгууллага юм шиг санагдаж байна.

Э.Сумьяа: Би түрүүн хэлсэн. Ажлын алба төсөвтэй болоход аль нэг төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарна. Энэ утгаар л тэгж туссан. Эргэж үзье.

Д.Батбаяр: Хаанаас санхүүжиж байна гэдгээс хамаарч тэр байгууллагын удирдлагадаа тайлагнах юм. Цалингийн сан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцаас гарч байх учраас Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад

тайлагнах болж байгаа юм. Эхний 1-2 жилдээ ингэж ажиллаж хөл дээрээ тогтох хэрэгтэй гэж Дэлхийн банкнаас зөвлөсөн.

Л.Зориг: Эхний асуудлаа батлаад дараагийн асуудалдаа ороод явах саналтай байна.

Ц.Банзрагч: Эхний асуудлаа батлах саналтай байна.

Алгаа: хуралдааны материал тараах хугацааг 4 доошгүй хоногийн өмнө гэж болгох саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Д.Батбаяр: Өөр саналгүй бол энэ асуудлыг гишүүдийн саналыг судалж тусгаад батлая.

ХЭЛЭЛЦСЭН нь: Д.Батбаяр хоёрдугаар асуудал болох ажлын хэсгийн шинэчилсэн төлөвлөгөөг Э.Сумьяа танилцуулна.

Э.Сумьяа: Бидний өмнө баталсан төлөвлөгөөтэй Дэлхийн банкны зөвлөхүүд танилцаад хэрэжүүлэх үйл ажиллагаа, зардал гэсэн 2 багана нэм гэж зөвлөсөн. Энэ дагуу төлөвлөгөөнд нэмэлт оруулсан. Мөн өнгөрсөн 10 дугаар сард Норвег Улсад олон улсын бага хурал болсон, тэндээс бодлогын зөвлөмж гарсан. Түүнийг төлөвлөгөөнд харгалзаж тодруулга хийсэн. Зардлын хувьд Засгийн газраас гарах зардлыг өөр өөрсдийн байгууллагаас гаргах зардлаа тооцож тусгасан. Хандивлагчдаас тусламж авахаар төсөл явуулсан. Санхүүжилтийн талаар өрсөлдөгч олон орон байгаа гэсэн үүднээс тодорхой хугацааны дараа хариугаа өгөхөө мэдэгдэж Европын холбоо, сайн дурын байгууллагуудад хандаж болно гэсэн зөвлөлгөөг Дэлхийн банкнаас өгөөд байна.

Ц.Ганболд: Санхүүжилтийн зардал хэдий хэмжээтэй вэ?

Э.Сумьяа: Зун 375000\$ зөвшөөрч байсан юм, одоо 290000-300000 ам \$ байхаар Дэлхийн банкнаас урьдчилан зөвшөөрсөн.

Д.Батбаяр: санхүүжилт ер нь хэдийд шийдэгдэх бол?

С.Хасар: Энэ сард багтаан санхүүжилтийг шийдвэрлэж өгөхөөр бид ажиллаж байгаа.

Ц.Ганболд: Оны эхэнд тайлангууд гаргах байх. Хуулинд зааснаар бол лиценз эзэмшиж байгаа компани бүгд тайлан гаргах болоод байгаа. Үүнийг төлөвлөгөөнд тусгах 3.4 сард тайлан гаргах, хэрэгжиж байгаа үйл явцын мониторинг хийж 6-12 дугаар сард хуралдаж болох юм. Сумаас Сангийн яам руу тайлан бүрдүүлэлт ирнэ. Орон нутагт тайланг гаргах мэргэжилтэн бэтгэхэд анхаарах, мөн вэб сайтын чиглэлээр 3 талын төлөөллүүд анхаарч үзээч, бид мэдээллийн талыг хариуцаж ажиллахад бэлэн байна.

Э.Сумьяа: Наад саналуудаа томъёолоод өгвөл төлөвлөгөөнд шууд тусгая.

Р.Батпүрэв- 10.1-10.2-т байгаа "хөндлөнгийн" гэдгийн оронд "бие даасан" гэсэн найруулгын хийх саналтай.

Л.Дондог: Санамж бичигтэй танилцсан. Ерөнхийд нь дэмжиж байна. 8.3-ийн "санхүүгийн ажилтан" гэснийг хасмаар байна. Нийтэд мэдээлэх ёстой, мэдээлээгүй бол яах вэ гэдгийг энд оруулах.

Л.Зориг: Олборлолт, ашиглалт гэдэг дээр санал хэлмээр байна. Олборлох үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын А лиценз эзэмшиж байгаа гэж оруулмаар байна.

Н.Дорждарь- 6.4-т байгаа "харилцан хяналттайгаар" гэснийг тодруулах

Э.Сумьяа: Харилцан хяналттай гэдэг нь бичгээр зөвшөөрнө гэдгийг санамж бичигт тусгасан санаа.

Л.Зориг: Бизнесийн нууцтай холбоотой гэдгээр тусгасан бол найруулгыг анхаарая. Харилцан хяналттай гэснийг хассан ч болох юм.

Э.Сумьяа: Саналыг хүлээн авч 6.4-ийг хасая.

Ц.Ганболд: Санамж бичигтээ хэзээ гарын үсгээ зурах вэ.

Э.Сумьяа: Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж зөвшөөрүүлээд гарын үсэг зурна.

Л.Дондог: Нийтэд мэдээлнэ гэдэг ямар утгаар вэ гэдгийг тодруулж оруулах нь зүйтэй. 7.3, 8.3-ыг эргэж харах.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Д.Батбаяр: Гишүүдийн саналыг тусгаж Үндэсний зөвлөлд оруулая.

ХЭЛЭЛЦСЭН нь: Д.Батбаяр 5 дугаар асуудал болох Тайлангийн маягт байгаа. Э.Сумьяа танилцуулна.

Э.Сумьяа: 1 дүгээр маягтыг аж ахуйн нэгж өөрөө гаргана, 2, 3 дугаар маягтыг Сангийн яам гаргана, 4 дүгээр маягтыг Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газар гаргана. Маягтыг хэрхэн гаргах заавар мөн боловсруулсан, зарим гишүүдээс санал авсан. НӨАТ-хэрэглээний татвар болохоор маргаантай. Дэлхийн банкны зөвлөх нэмэгдсэн өртгийн татвар эргэн олгогддог учир зарим улс оруулаагүй, зарим улс оруулсан, аудит хийхэд хүндрэлтэй гэсэн. Иймд үүнийг ажлын хэсэг дээр ярья гээд оруулаад ирсэн. Мөн яамнаас эхлээд сум орон нутаг иргэдэд үзүүлсэн дэмжлэгийг оруулсан, энд мөнгөн бус дэмжлэг ч орж байгаа, түүнийг мөнгө болгон оруулна. Байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн зардал тусгахаар төрийн бус байгууллагын эвслээс гаргасан саналыг мөн оруулсан, санд төвлөрүүлсэн мөнгө нөхөн

сэргээлт хийхээр буцаан олгодог. Үүнийг бас ярилцах хэрэгтэй гэв.

Н.Дорждарь: Төрийн бус байгууллагын эвсэлд маягт дээр ярих зарчмын асуудал байна. Бид ярилцсан. Тайлангийн эхний хэсэгт тайлан өгч байгаа 2 талын зөрүү гарах нь бага байх. 2 дугаар хэсэгт байгаа үзүүлэлтүүд сайн дурын биш албан ёсны байх нь зүйтэй. Энд л зөрүү гарна. Уурхай тус бүрээр гол зардлыг гаргах боломж бий юу. Техникийн чанартай зүйлд Маягт 1, 4 дээр борлуулалтын хэсгийг үйлдвэрлэлт, борлуулалт гэж салгаад, маягтанд үйлдвэрлэсэн, борлуулсан мөнгөн тоон үзүүлэлт, үйлдвэрлэлт, борлуулалтын хэмжээг ялгаж харах зорилгоор 1 багана нэмж оруулая. НӨАТ байлгая. Харин НӨТ-ийг буцаан олголтыг компаниудад сайн дураар тайлагнах бололцоо бий. Сайн дураар тайлагнах хэсэгт хөрөнгө оруулалтын мэдээ, дүрмийн сан, ашиг хуваарилах зарчим, бусдаас авсан ашиг, нийт ашиг, хайгуулын зардал, ажилчдын цалин, урамшуулал, нийгмийн асуудлыг нэмж оруулбал тайланг ил тод болгох боломжтой юм. Би саналаа бичээд өгөө.

Ц.Ганболд: Компаниудад олон газар олборлолт хийж байгааг нийтэд мэдээллэх, сум аймагт мэдээлэх, сумын татварын байцаагч тайлагнадаг байдалд шилжүүлдэг байхыг судалж ажил болгох. Эндээс арай ойрхон тоо гарах болов уу гэж бодож байна. Энэ нь тайланг компаниуд нийт дүнгээр бус тусгай зөвшөөрөл тус бүрээр гаргах боломж бий болгох. Тайлангийн маягт ийм байвал орон нутагтаа мэдээлэх боломж нэмэгдэнэ.

Л.Дондог: 2 дугаар маягтын дагуу гаргахад Сангийн яамны тайланд зөрүү гарах магадлалтай юм. Үүнийг анхаарах, учир нь аж ахуйн нэгжийн тайлан Сангийн яаманд ирдэг тул шууд хуулах талтай.

Д.Дашзэвэг: Компаниуд үйл ажиллагаа явуулдаг орон нутагтаа их тусалдаг. Тээврээр хүртэл үйлчилнэ, гэхдээ хийсэн үр дүнг нь орон нутгийн удирдлага өөрсдийн хийсэн ажил болж гардаг. Иймд тусламж, дэмжлэгийг мөнгөөр илэрхийлж тусгах нь зүйтэй юм.

Б.Болдбаатар: Хайгуулын лиценз эзэмшигчийг ил тод байлгах, зарим лиценз эзэмшигч нь лицензээ зарсан зардлаасаа татвар төлөхгүй байна. Үүнийг тусгах уу.

Ц.Ганболд: Энэ байдлыг тодруулах хэрэгтэй юм. Арилжаа хийгдээд байхад эндээс татвар авах хэрэгтэй байна.

Ц.Даваадорж: Энэ талаар манай яам ярилцан судалж байгаа. Гадаадын байгууллагын төлөөлөгчидтэй ярилцаж байна. Канадын байгууллагатай хамтран олон улсын жишгээр шийдвэрлэхээр 2 хүн гадаадад сургалтанд сургах гэж байна. Лицензийн наймааг зогсоох арга байхгүй, харин яаж

татваржуулах вэ? Ашгийг яаж олж тогтоох нь ээдрээтэй байгаа. Үүн дээр бид ажиллаж байгаа.

Л.Зориг: Энэ нь өнөөдрийн асуудалд холбоогүй учир энэ асуудлыг дараа ярьсан нь дээр байх. Маягтыг Сангийн яамтай эргэж ярья гэсэн саналтай байгаа. Нэмэгдсэн өртгийн албан таварыг цэвэрлэсэн байдлаар оруулах нь зүйтэй. Манайх Сангийн яамтай хамтарч саналаа өгөө. Сум орон нутгийн хувьд мэдээлэл хийх нь хэрэгтэй зүйл. Эхний ээлжинд толгой компанийн тайлангаар явдаг. Татварын байцаагчдын хувьд гэхэд манайх цалинг л өгдөг, бусад ажлын байр, ширээ сандлаас эхлээд унаа хүртэл орон нутаг хангадаг.

Д.Дашзэвэг: Энэ асуудал дээр манай байгууллагын хувьд ч илүү их тохиолддог. Суманд орж байгаа компанийн хөрөнгө оруулалтыг орхигдуулж байдаг. Тиймээс ядаж Иргэдийн төлөөлөгчдийн хуралд мэдээлэл хийж байх нь зүйтэй.

Ц.Банзрагч: Сангийн яамны санал ирээгүй байхад бид дараа дахин ярьсан нь дээр юм.

Р.Батбилэг- Компани тайлангаа сумандаа мэдээлэх, аймаг, сумын Засаг компаниас юу авснаа иргэдээ мэдээлэх нь чухал.

Содхүү: Хоёр дахь хэсгийг яам, агентлаг үзүүлсэн дэмжлэг, суманд үзүүлсэн дэмжлэг, аймагт үзүүлсэн дэмжлэг, орон нутгийн харилцаа, тогтвортой хөгжилд зарцуулсан хөрөнгө мөнгө гэж оруулая. Байгаль хамгаалах сангийн хэсэг тусдаа байя.

Б.Болдбаатар-Компани бусдад, төрийн бус байгууллагад ч хандив өгдөг, татварын дараахь ашгаасаа хандив өгдөг.

Алгаа-мэдээлэх хэлбэрийн хувьд өдөр тутмын сонин гэжээ. Жижиг брошюр болгон хэвлэх, веб сайтад тавих, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, орон нутгийн сонинд тавих гээд олон хэлбэр байж болно.

Л.Дондог: Хэрвээ орон нутгийн дэмжлэгийг маягт оруулна гэвэл, маягтад бүгдий нь задаргаатай буюу хавсралттай авч тусгах шаардлага гарна. Мэдээллийг бусад хэлбэрээр ч хийж болно.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Д.Батбаяр: Энэ асуудлаар Сангийн яамтай ярьж ойрын хугацаанд санал авая. Маягтыг эцэслэн боловсруулахад Л.Дондог, Ц.Ганболд, Алгаа нарыг оруулья.

ХЭЛЭЛЦСЭН нь: Д.Батбаяр: Төрийн захиргааны байгууллагын чиг үүргээ хэлэлцүүлээ.

Л.Зориг: Энэ ер нь ямар зорилготой баримт бичиг вэ?

Э.Сумъяа-Санаачлагыг хэрэгжүүлэхэд оролцогч Засгийн газрын байгуулагуудын чиг үүргийг тодорхойлж байгаа баримт бичиг. Санаачлагыг хэрэгжүүлэхэд энэ чиг үүргийн дагуу тухайн байгууллагыг үүрэгжүүлж ажиллана.

Л.Зориг-Төрийн өмчийн хороо ноогдол ашиг авдаг учир оруулая.

Э.Сумъяа-Саналыг тусгана.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүрэгт гарсан саналыг тусган Үндэсний зөвлөлд танилцуулахаар тогтов.

Танилцуулсан нь: Д.Батбаяр: Танилцуулах асуудал Норвеги явсан ажлын тайлан байгаа.


Э.Сумъяа: Норвегийн олон улсын бага хурлын зөвлөмж ном орчуулагдаж Нээлттэй нийгэм форум хэвлэж гарын авлага болгон ойрын үед гарна.

Д.Батбаяр: Хуралдаанаар төлөвлөсөн асуудлаар гишүүд санал гаргалаа, амжилттай хэлэлцлээ. Олон асуудлаар ойлголцолд хүрлээ. Хэлэлцэх асуудлуудаар зохих ёсны шийдвэр гаргалаа. Ажлын хэсэг хамтын үйл ажиллагаагаа өргөжүүлэх, бие биенээ сонсож ажиллана, хэлэлцсэн асуудлыг эцсийн найруулга болгож Үндэсний зөвлөлд оруулна. Үндэсний Зөвлөлийн хурал 1 дүгээр сарын 11-нд хуралдана. Ажлын хэсэг дэмжих бүлгийг ойрын хугацаанд зохион байгуулалтанд оруулахыг Э.Сумъяад даалгалаа. Үүнийг дэмжиж ажиллахыг гишүүдээс хүслээ.

Хурал 17.05 дуусав.

Хуралдааны тэмдэглэл хөтөлсөн:


Шинжээч



Д.БЯМБАДУЛАМ

Хянасан

Засгийн газрын ахлах референт,  
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга



Э.СУМБЯА